

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МОНГОЛ КУВЕЙТ БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨВ ТӨААТҮГ-ЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/110/НА-СТА-ТӨА

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024 он	Санхүү-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Ч.Болд Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.gov.mn Аудитор: А.Баясгалан Утас: 261628 Цахим хаяг: bayasgalana@audit.gov.mn “Амгалан Ахуй Аудит” ХХК-ийн захирал: Д.Амгалан Утас: 88054499 Цахим хаяг: amgalanahui.audit@gmail.com
-----------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.03.15 № 07/450
танай _____-ны № _____-т

МОНГОЛ КУВЕЙТ БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ТӨВ ТӨААТҮГ-ЫН
ЗАХИРАЛ Х.ЕРХУЛАН ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монгол Кувейт байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Монгол Кувейт байгаль хамгаалах төв ТӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлангийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 575.6 сая төгрөгөөр өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төрийн хэмнэлтийн хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-д заасантай тус тус нийцээгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус ТӨААТҮГ нь байгаль орчин аялал жуулчлалыг хөгжүүлэх, мэдээлэл, сургалт, суртчилгааны ажил зохион байгуулах чиг үүрэг бүхий байгууллага бөгөөд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлд "сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах, ...сурталчлах зэргийг санхүүжүүлэхийг хориглосон"-оос зарим чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл бүрдээгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд орлогыг 912.0 сая төгрөг, зардлыг 904.7 сая төгрөг, цэвэр ашгийг 7.4

Z:\Yawsan_Bichig\2024\0315_SNAG-48.Docx

0001051524

сая төгрөг байхаар баталсан байна. Гүйцэтгэлээр 407.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 824.7 сая төгрөгийн зардал гарган, 417.2 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн тайланд 1 зорилтын хүрээнд 3 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 48.7 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	325,134.01	3,142,587.89
1.1.2	Дансны авлага	-	4,046,074.90
1.1.6	Бараа материал	106,559,877.03	34,537,479.25
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	106,885,011.04	41,726,142.04
1.2.1	Үндсэн хөрөнгө	4,763,635,066.93	4,589,093,443.23
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,763,635,066.93	4,589,093,443.23
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	4,870,520,077.98	4,630,819,585.27
2.1.1.1	Дансны өглөг	55,418,383.11	155,983,149.50
2.1.1.2	Цалингийн өглөг	-	2,228,085.00
2.1.1.3	Татварын өр	147,247,459.61	192,030,187.40
2.1.1.4	НДШ - ийн өглөг	10,298,146.14	44,283,849.14
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	212,963,988.86	394,525,271.04
2.2	Өр төлбөрийн нийт дүн	212,963,988.86	394,525,271.04
2.3.1	Өмч: - төрийн	7,880,761,400.00	7,880,761,400.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	(1,943,234,895.40)	(1,943,234,895.40)
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(1,279,970,415.48)	(1,701,232,190.37)
2.3.9.11	Өмнөх үеийн хуримтлагдсан ашиг	(1,279,970,415.48)	(1,283,788,915.37)
2.3.10	Тайлант үеийн хур ашиг	-	(417,443,275.00)
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	4,657,556,089.12	4,236,294,314.23
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	4,870,520,077.98	4,630,819,585.28

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	585,882,523.90	407,528,909.09
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	-	166,432,312.56
3	Нийт ашиг (алдагдал)	-	241,096,596.53
10	Ерөнхий ба удирдлагын зардал	892,239,484.95	658,522,010.68
12	Бусад зардал	-	17,860.85
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(306,356,961.06)	(417,443,275.00)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(306,356,961.06)	(417,443,275.00)
22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(306,356,961.06)	(417,443,275.00)
24	Орлогын нийт дүн	(306,356,961.06)	(417,443,275.00)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2021 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	7,880,761,400.00	-	(973,613,454.42)	6,907,147,945.58
Залруулсан үлдэгдэл	7,880,761,400.00	-	(973,613,454.42)	6,907,147,945.58
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(306,356,961.06)	(306,356,961.06)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	(1,943,234,895.40)	-	(1,943,234,895.40)
2022 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,279,970,415.48)	4,657,556,089.12
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(3,818,499.89)	(3,818,499.89)
Залруулсан үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,283,788,915.37)	4,653,737,589.23
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	(417,443,275.00)	(417,443,275.00)
2023 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл	7,880,761,400.00	(1,943,234,895.40)	(1,701,232,190.37)	4,236,294,314.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	646,972,638.29	444,572,300.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	538,172,981.29	25,650,000.00
1.2.9	Бусад мөнгөн орлого	108,799,657.00	418,922,300.00
1.2	Мөнгөн зарлага (-)	656,296,610.89	441,754,846.12
1.2.1	Ажиллагчдад төлсөн	238,490,595.88	177,457,737.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	-	8,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	192,332,604.26	164,587,734.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	154,427,468.49	71,568,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	71,045,942.26	20,141,374.23
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(9,323,972.60)	2,817,453.88
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,960,000.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,465,000.00	-
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	495,000.00	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(1,960,000.00)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(11,283,972.60)	2,817,453.88
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,405,715.57	325,134.01
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	325,134.01	3,142,587.89

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Үзүүлэлтүүд	2022 оны гүйцэтгэл	2023 оны			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1.1	Хоол үйлдвэрлэлт	433,208.6	552,000.0	203,439.8	348,560.2	36.9
1.2	Экологийн боловсрол олгох сургалт	126,051.3	155,000.0	147,956.6	7,043.4	95.5
1.3	Хурал семинар зохион байгуулснаас орох орлого	68,300.0	110,000.0	31,080.0	78,920.0	28.3
1.4	Бусад орлого	8,000.0	95,000.0	25,052.5	69,947.5	26.4
1	Нийт орлого	635,559.9	912,000.0	407,528.9	504,471.1	44.7
2	Нийт зардал	824,069.4	904,473.5	824,972.1	71,521.1	92.0
	Үүнээс: Удирдлагын зардал	45,129.0	62,312.3	62,312.3	-	100.0
3	Татварын өмнөх ашиг	(188,509.5)	7,526.5	(417,443.2)	424,969.7	-
4	Цэвэр ашиг/алдагдал	(188,509.5)	7,451.3	(417,443.2)	424,894.5	-
5	Төсвийн төлбөрт	92,495.0	47,969.8	24,554.0	23,415.8	51.2
6	Төрийн өмчийн ногдол ашигт	-	-	-	-	-
7	Нийт ажиллагсдын тоо	15.0	19.0	13.0	6.0	68.4
8	Хөрөнгө оруулалт	-	72,049.0	-	72,049.0	-
9	Нийт авлага	6,797.7	-	4,046.0	(4,046.0)	-
	Үүнээс: Найдваргүй	-	-	-	-	-
10	Нийт өглөг:	155,364.0	178,384.0	394,525.3	216,141.3	221.2
	Богино хугацаат өр төлбөр	155,364.0	178,384.0	394,525.3	216,141.3	221.2
	Урт хугацаат өр төлбөр	-	-	-	-	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 234.7 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 234.7 сая төгрөгийн алдааг залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Тайлант онд үндсэн үйл ажиллагааны орлого 444,276.3 мянган төгрөг, бусад орлого 132.0 мянган төгрөг олсныг санхүүгийн үр дүнгийн тайланд 10,547.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.	1	10,547.0			1	10,547.0	1	10,547.0				
Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайланд үндсэн үйл ажиллагааны орлого 444,572.3 мянган төгрөг олсныг цахим нэхэмжлэх үүсгээгүй, ААНОАТ-д 245,643.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	198,929.3			1	198,929.3	1	198,929.3				
Дансны авлага 10,582.4 мянган төгрөгийг өр төлбөр дансанд бууруулж бүртгэсэн байна.	1	10,582.4			1	10,582.4	1	10,582.4				
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого, шууд бус орлогод ногдуулан суутгасан албан татварын тайлан, нийгмийн даатгалын тайланд ажилчдын цалинг 14,230.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.	1	14,230.0			1	5,695.0	1	5,695.0				
Тайлант онд хөрөнгийн ашиглалтын жилийг буруу оруулсан 905.0 мянган төгрөг, ангилал буруу 439.7 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн тодруулга, санхүүгийн тайлангаас зөрүүтэй байна.	1	439.7			1	439.7	1	439.7				
Дүн	5	234,728.4			5	234,728.4	5	234,728.4				

Аудитаар нийт 1,088.9 сая төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 901.0 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 187.7 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Компанийн 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, 905.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан байна.	1	905.0					1	905.0				
Тайлант онд 186,793.2 мянган төгрөгийн анхан шатны е баримтгүй бараа материал, бэлэн бүтээгдэхүүн худалдан авсан байна.	1	186,793.2					1	186,793.2				
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаагүй, 136,146.4 мянган төгрөгийн хүнсний материал худалдан авсан байна.	1	136,146.4			1	136,146.4						
Тайлант онд 24,032.6 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.	1	24,032.6			1	24,032.6						
Татварын 192,030.2 мянган төгрөг, нийгмийн даатгалын 44,283.8 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	1	236,314.0			1	236,314.0						
Давхар ажил эрхэлдэг 2 ажилтанд ХХОАТ-ын хөнгөлөлтийг зөрүүтэй тооцоноос 269.5 мянган төгрөгийн цалинг илүү олгосон байна.	1	269.5	1	269.5								
Тайлант онд байгууллагаас хийгдсэн жилийн эцсийн тооллогоор илүүдсэн хөрөнгө, хангамж, бараа материалыг санхүүгийн тайланд орлогоор бүртгээгүй байна.	1						1					
Дүн	7	584,460.8	1	269.5	3	396,493.1	3	187,698.2				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 504,4 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 504,4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулах мэдээллийн 3 хугацаа хоцроож байршуулсан байна.	1		1			
Дүн	1	-	1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Эдийн засгийн үндсэн үзүүлэлтийг 4, зорилтот түвшинг 912.0 сая төгрөгөөр гүйцэтгэлээр 2 үзүүлэлтээр 407.5 сая төгрөг байна. Энэ нь эдийн засгийн үндсэн үзүүлэлтийн дагуу орлогыг ангилж бүртгээгүй, үндэслэлтэй төлөвлөөгүй, зорилтод түвшнээс 475.6 сая төгрөгөөр дутуу байна.	1	504,471.1	1	504,471.1		
Дүн	1	504,471.1	1	504,471.1		
Нийт дүн	2	504,471.1	2	504,471.1		